



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 1/831

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг-Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/323 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020004223

Нийслэлийн Засаг даргын 2016 оны  
11 дугаар сарын 23-ны өдрийн  
А/831 дугаар захирамжийн хавсралт



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Аялал жуулчлалын газар (цаашид “Газар” гэх) нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3. Газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4.2-т заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4. Газар үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж, тайлагнана.

1.5. Газар зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

### Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1. Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2. Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга, орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга тус тус томилж чөлөөлнө.

2.3. Газар үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга батална.

2.4. Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

## 2.5. Газрын дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1. батлагдсан бүтэц, орон тоо болон хуулиар тогтоосон эрх, хэмжээний хүрээнд ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2. холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

2.5.3. хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

2.5.4. орлогч дарга, хэлтсийн дарга, албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

2.5.5. байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.5.6. газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.5.7. сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.8. ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.10. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

2.6. Газрын дарга, албан хаагчид Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

2.7. Газрын дарга хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллана.

Гурав. Газрын үндсэн чиг үүрэг

## 3.1. Газар дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн чиглэлээр хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний

чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.2. жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

3.1.3. аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;

3.1.4. аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.1.5. аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах;

3.1.6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.7. гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.1.8. аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх;

3.1.9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;

3.1.10. аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах;

3.1.11. гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, Улаанбаатар хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах;

3.1.12. гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах;

3.1.13.жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.14.жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.1.15.нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх;

3.1.16.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

3.1.17.гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

3.1.18.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

#### Дөрөв. Хариуцлага

4.1.Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### Тав. Бусад зүйл

5.1.Энэ дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

5.2.Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

---o0o---